

*С.Энхдотно - Хууль сахиулах удирдлагын академийн
8042 дугаар дамжсааны суралцагч хошууч
Я.Ариунболд - Хилийн албаны удирдлага. стратегийн
профессорын багийн профессор, хурандаа*

ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХҮН МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧИН ГАРСАН ҮЕИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хураангуй: Энэхүү нийтлэлээр хил орчмын нутаг дэвсгэрийн тухай ойлголт, түүнд үүссэн хүч малын гоц халдварт өвчний үеийн удирдлага зохион байгуулалтын талаар авч үзлээ.

Түлхүүр үг: Хил, нутаг дэвсгэр, хүн малын гоц халдварт өвчин, удирдлага, зохион байгуулалт:

Оршил: Дэлхийн уур амьсгал сүүлийн жилүүдэд ихээхэн өөрчлөгдөж дулаарч байгаагаас шалтгаалан улс орнуудад тохиолддог гамшгийн давтамж ойртож, учрах хохирол эрс нэмэгдсээр байгаа бөгөөд шинжлэх ухаан, технологийн дэвшил түргэн хурдацтай хөгжих тусам улс орнуудад биологийн, химийн шинэ төрлийн зэвсэг бүтээх түүнийг улам боловсронгуй болгох аюул нүүрлэж байна.

Хэдийгээр олон улсын эрх зүйн зохицуулалтаар хориглож байгаа ч хүн төрөлхтөн цэрэг дайны зорилгоор хими, биологийн аюултай хор хөнөөл учруулагч, үүсгэгчүүдийг зэвсгийн зориулалтаар ашиглахад бэлэн хадгалалтад байлгасаар л байна. Биологийн онцлогийн хувьд агаарт маш амархан тархан, их талбайг хамарч, олон хүнийг үхүүлэх чадалтай боом, тарваган тахал, бруцеллёз, цагаан цэцэг, энцефалит, цусархаг чичрэг (Anthrax, Plague, Brucellosis, Smallpox, Viral, Encephalidites, Viral hemorrhagic fever) зэрэг өвчин үүсгэгчдийн хэрэглэж олон зуун мянган хүнийг өвчлүүлэн, үхүүлж байсан түүхийг мартаж болохгүй.

Монгол Улсын хувьд хүн, мал, амьтны гоц халдварт өвчнүүдийн гаралт, түүний давтамж, тархалт ихсэж улсын эдийн засаг, иргэдийн амь насанд хохирол учруулж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд байгалийн гаралтай аюулт үзэгдлүүдийн давтамж ойртон урьд өмнө гарч байгаагүй шинэ төрлийн болон устсан гэж үзэж байсан хүн, мал, амьтны гоц халдварт өвчин халдварлан тархаж ихээхэн хэмжээний хохирол, зардал чирэгдэл гаргасан.

Монгол Улсын Их хурлаас 2017 оны 2 дугаар сарын 02-ны өдөр "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн шинэчилсэн найруулга батлагдан гарсан бөгөөд гамшиг гэж "...аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь

нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн нооц, боломжоос давсан хохирол учрах¹ж тодорхойлсон.

Аюулт үзэгдэл гэж "...хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгч тархах² гэж тодорхойлсон. Биологийн гарвалтай холбоотой аюулт үзэгдэлд хүн мал, ургамлын гоц халдварт өвчин, хөнөөлт мэрэгчдийн тархалт зэрэг өвчин, тахлыг оруулдаг байна.

Гоц халдварт өвчний үүсгэгчид нь янз бүр, тэдгээр микробууд нь ердийн нүдээр үзэгдэхгүй, үнэр буюу өнгөгүй бичил биетнүүд бөгөөд гадаад орчинд ялангуяа хүйтэн цагт удаан хугацаагаар амьдрах чадвартайгаас гадна тохиромжтой нөхцөлд өсөн үрждэг. Бие махбодид уг микробууд нь амьдран хооллоод зогсохгүй өвчин үүсгэж, амь насыгхохироох аюулд хүргэх ба үүссэн өвчнүүд нь гол төлөв халдвартай байдаг.

Онцгой байдал гэж олон хүний амь нас үрэгдэх, эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулах, их хэмжээний эд баялгийг сүйрэлд хүргэх, хүний амьдрал ахуй, оршин тогтнох нөхцлийг бусниулах хэмжээний осол сүйрэл, байгалийн аюултай үзэгдэлээс болж тодорхой нутаг дэвсгэрт үүссэн цагийн байдлыг хэлнэ гэж томъёолж болох юм.

Хил орчмын нутаг дэвсгэрт³ гарсан хүн малын гоц халдварт өвчин гарсан үеийн хилийн ангийн удирдлага зохион байгуулалт нь Монгол Улсын хилийн бүс, зурваст гарсан гоц халдварт өвчин гарсан тохиолдолд тухайн хэсгийг хариуцсан хилийн анги хорио цээрийн дэглэм тогтоох, хил хамгаалалтыг өөрчлөн зохион байгуулах үүрэгтэй тул уг ажиллагааг явуулах эрх зүйн зохицуулалтын талаар товч авч үзэх шаардлага урган гарна.

Хилийн анги, салбар нь хилийн зурвас⁴, бүсэд⁵ байрладаг учраас хүн, мал, амьтны гоц халдварт өвчин хил орчмын нутаг дэвсгэрт гарсан үед

¹Монгол Улсын Гамшгаас хамгаалах хууль. //Төрийн мэдээлэл. 2008. №

²[www.nema.gov.mn]²

³Хил орчмын нутаг дэвсгэр гэж хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг хэлнэ. Монгол Улсын Хилийн тухай хууль. 1 дүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 1.14. / Төрийн мэдээлэл. 2017. № 6.

⁴ Улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, хилийн инженер. техникийн байгууламж барих зориулалтаар улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэ. Монгол Улсын Хилийн тухай хууль. 3 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 6.1. //Төрийн мэдээлэл. 2017. № 06/963

⁵ Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн бүс гэх бөгөөд түүний өргөнийг улсын хил хамгаалах байгууллага тухайн нэгжийн Засаг даргатай

хамгийн түрүүнд түүнийг илрүүлэх, мэдээлэх анхны арга хэмжээ авах шаардлага тулгардаг.

Хилийн анги гоц халдварт өвчинтэй тэмцэх асуудалнь хилийн бүс. зурваст бий болсон өвчний голомтыг хязгаарлах. хариуцсан хэсгийн хил хамгаалалтыг тасралтгүй явуулах тухайн нөхцөлийг далимдуулан гарч болох хилийн зөрчил. будлианаас урьдчилан сэргийлэх. бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах. өвчний хор хөнөөлийг арилгахад чиглэгдсэн байх ёстой.

Хилийн анги. салбар, харуулын байнгын байрлалын ойролцоо буюу хилийн зурвас бүсэд аюулт үзэгдэл тохиолдсон. түүнд хилчид. хил хамгаалах байгууллагын байрлал. мал. амьтан өртсөн тохиолдолд түүнтэй тэмцэх ажиллагаанд хилийн анги оролцож, мэргэжлийн болон харилцан ажиллагаатай байгууллагуудын хүч, оролцоог өргөнөөр ашиглана¹.

Хүн. мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үед хилийн анги нь улсын хил хамгаалалтын үүргийг сулруулахгүй байх, аюулт үзэгдэлтэй тэмцэх арга хэмжээг цагийн байдлын дагуу төлөвлөн аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг цаг алдалгүй хэрэгжүүлэх, түүнд оролцох харилцан ажиллагаатай байгууллагууд болон иргэдийн үйл ажиллагаагуялдуулан зохицуулах, бие бүрэлдэхүүн, голомтод ажиллаж буй бүлгүүдийн аюулгүй байдлыг сахих, бусад хэсэгт өвчний голомт тархахаас урьдчилан сэргийлэхэд гол анхаарлаа чиглүүлнэ.

Хилийн бүс, зурваст гоц халдвар тархсантай мэдээ авагдсан тохиолдолд ангийн захирагч, штаб уг мэдээллийг магадлан шалгаж, бодитой болох нь тогтоогдвол Хил хамгаалалтыг удирдах төрийн захиргааны байгууллагын даргад нэн даруй илтгэнэ.

Хилийн анги дээрх цагийн байдлын мэдээ авмагц зохион байгуулалтын дараах ажиллагааг явуулна. Үүнд:

Үүсч бий болсон нөхцөл байдлын талаарх мэдээг тодруулж магадлан шалгах:

- хариуцсан хэсэгт нь өвчин гарсан заставын дарга, орлогч нарт үүрэг өгч нөхцөл байдлыг тодруулах;
- хэрэв уг мэдээг өөр шугамаар олж авсан бол анги, салбараас хүн томилж шалгуулах, тагнуулын шугамаар тодотгох;
- шаардлагатай гэж үзвэл хилийн ангиас шуурхай ажиллагааны бүлэг томилж магадлах;

зөвшилцсөний үндсэн дээр улсын хилийн шугамаас 100 км-ээс илүүгүйгээр тогтооно. Мөн хууль. 10.1.

¹Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм. 2006 он

Ахлах даргад үүсч бий болсон цагийн байдлын талаар нэн даруй илтгэхдээ: утсаар тухай бүр нь, удирдлагын холбоогоор заасан хугацаанд, шаардлагатай гэж үзвэл албан бичгээр тус тус илтгэнэ.

Хилийн бүс, зурваст гоц халдварт өвчин гарсан үед хилийн ангийн захирагч орон нутаг дахь онцгой байдлын асуудал хариуцсан алба, харилцан ажиллагаатай байгууллагуудтай мэдээлэл солилцож, мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох бөгөөд энэ чиглэлээр хил залгаа улсын хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж болно.

Улсын хилийн бүс, зурваст олон улсын хөл хориот, гоц халдварт өвчин гарсан үед "Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ"-г мөрдөх бөгөөд уг гэрээ 1988 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Уг гэрээнд хүн, мал, амьтны халдварт өвчин гарсан үед харилцан мэдээлэх, хил давахаас сэргийлэх арга хэмжээ авахаар тусгасан, хоёр талаас хилийн төлөөлөгчийн уулзалтаар энэ асуудлуудын талаар авч үздэг байна.

Мөн МУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд "Мал, амьтны хорио цээр болон мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр"-ийг 1994 оны 4 дүгээр сарын 29-нөөс эхлэн мөрдөж байна.

Хил орчмын нутаг дэвсгэрт хүн малын гоц халдварт өвчин гарсан үеийн удирдага зохион байгуулалтын арга хэмжээг хилийн ангийн захирагч дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд: онцгой комисс, шуурхай бүлэгтэй мэдээ, мэдээлэл солилцож, харилцан ажиллана;

- Орон нутгийн Онцгой байдлын газарт үүссэн нөхцөл байдлын талаар мэдээлэх;
- Орон нутгийн Онцгой байдлын газар болон харилцан ажиллагаатай байгууллагуудаас ямар хүч хэрэгслийг оролцуулах;
- Цугларах районыг тогтоох, харилцан ажиллагааг тодотгох;
- Ямар районд хөл хорио тогтоох;
- Хаанаас ямар хэмжээний хүн, мал, эд материалыг ямар журмаар нүүлгэн шилжүүлэх;
- Мэргэжлийн байгууллагуудтай хамтран устгал хийх районыг тогтооно.

Хилийн зурвас, бүсэд аюулт үзэгдэл тохиолдсон үед аюулт үзэгдлээс хамгаалах ангийнурьдчилсан ажиллагааны төлөвлөгөө, Хил хамгаалалтыг удирдах төрийн захиргааны байгууллагын даргын өгсөн үүргийн дагуу ангийн

захирагч улсын хил хамгаалалтыг ямар хэлбэр, зааг, хүч хэрэгслээр өөрчлөн зохион байгуулах шийдвэрийг шинээр боловсруулж, хэрэгжүүлнэ.

Хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үед дараах байгууллагууд хамтран ажиллаж өөр өөрийн онцлог үүргүүдийг биелүүлдэг. Эдгээр байгууллагуудад: Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам. Байгалийн гоц халдварт өвчинтэй тэмцэх үндэсний төв, Халдварт өвчнийг судлах үндэсний төв, Эрүүл мэндийн газрууд, Хүнс, хөдөө аж ахуйн яам. Улсын мал эмнэлгийн газар. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Хүнс, хөдөө аж ахуйн газар /орон нутгийн мал эмнэлгийн албад/ Улсын мэргэжлийн хяналтын газар. аймгийн мэргэжлийн хяналтын газар. сумдын хөдөө аж ахуйн байцаагчид. Цагдаагийн ерөнхий газар /аймгийн цагдаагийн газар, хэлтсүүд/. Сум, дүүргийн ЗДТГ, харъяа албад, иргэн, аж ахуйн нэгж. өрхийн эмнэлгүүд. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд тус тус байдаг бол анагаах ухааны их сургууль, хөдөө аж ахуйн их сургуулийн багш. оюутнууд, дотоодын цэрэг, Зэвсэгт хүчний тусгай мэргэжлийн ангиуд /хими. инженер г.м/-аас болон ерөнхий цэрэг, хилийн цэргийн анги, салбарууд, орон нутгийн ард иргэд дайчилгаагаар томилогдон ажиллаж болох юм.

Дүгнэлт: Манай Улсын хувьд сүүлийн 10 жилд тохиолдсон аюулт үзэгдлийн судалгаанаас үзэхэд хүний гоц болон хурц халдварт өвчин 119, малын гоц халдварт өвчин 136, шувууны томуу өвчин 3 удаа гарч нийт 900 хүн өвчилж, 9.2 сая мал хорогдож маш их хэмжээний хохирол учирсан байна. Судалгаанаас үзэхэд хүн, мал, амьтны гоц халдварт өвчин нь улс үндэстний хилээр хязгаарлагдахгүйгээр маш түргэн хугацаанд тархаж, хүн, мал, амьтдыг богино хугацаанд олноор нь өвчлүүлж үхлийн аюулд хүргэдэг ба улсын эдийн засагт асар их хохирол учруулдаг болох нь харагдаж байна. Хил орчмын нутагт хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах үед хилийн боомтыг улсын мал эмнэлгийн төв албаны дүгнэлт, Засгийн газрын шийдвэрийг үндэслэн тодорхой хугацаанд хаах хүртэл арга хэмжээ авна.

Дэвшүүлж буй санал: Судалгаанаас үзвэл хүн. малын гоц халдварт өвчний 40 хувь нь хилийн зурвас, бүсэд гарч байгаа нь хил хамгаалах байгууллагын анги салбаруудыг түүнтэй тэмцэхэд ашиглах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Иймээс хүн, мал, амьтны гоц халдвар тархалтын үед тогтоох хорио цээрийн дэглэмийн үед ажиллах үүрэг бүхий мэргэжлийн бусад байгууллагуудад туслах, дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлээр тусгай томилгоот бүлгүүдийг бэлтгэн, сурган дадлагажуулах асуудал хилийн цэргийн анги салбаруудад зайлшгүй тавигдаж байна.

1. Хил орчмын нутаг дэвсгэрт гарч буй халдварт өвчний эх үүсвэр, өвчний тархалт, дэгдэлтийн байдалд судалгаа дүгнэлт хийж гоц халдварт өвчинтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, халдвар эсэргүүцэх арга хэмжээний талаар нэгдсэн сургалт, дадлага явуулах;

2. Хилийн анги, салбарт энэ чиглэлээр ажиллах мэргэжилтэн дутмаг, шаардлагатай орчин үеийн техник хэрэгсэл байхгүй, энэ чиглэлээр хийгдэж байгаа судалгаа, шинжилгээний ажлын тоо хэмжээ, нэр төрөл, цар хүрээ хангалтгүй, шуурхай удирдлага зохицуулалт дутагдалтай, бие бүрэлдэхүүн гоц халдварт өвчний талаар мэдлэг сул, бүлгүүд сургагдаагүй байна. Хилийн анги, салбараас хорио цээрийн дэглэмийн бүсэд ажиллах бүлгийг томилгоожуулах, тэднийг сургаж бэлтгэх, бүлэгт шаардагдах техник, тусгай хэрэгсэл, ариутгалын багаж, бодис, хамгаалалтын хувцас, шаардлагатай хүнс, шатахуун, байр, санхүүгийн болон бусад нөөцүүдийг бий болгох зэрэг асуудлыг санал болгож байна.